

И.Я.КОРОСТОВЕЦ МОНГОЛЫН АНХНЫ СОНИНЫ ҮҮСЭЛД  
ХОЛБОГДОХ ТУХАЙД

Л.Норовсүрэн\*, Ц.Батбаатар\*\*

\* Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

\*\* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант

**Түлхүүр үгс:** соёл, гэрээ, Монгол, Орос, сонин, зорилго, үндэсний үзэл, ашиг сонирхол, төрийн бодлого, түүх, хэвлэх үйлдвэр

**М**онгол Улс дэлхий нийтийн жишгийг дагаж улс төрийн ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн зам мөрийг сонгосон цагаас үндэсний аюулгүй байдлын дархлаа болсон түүх, соёлынхоо уламжлалыг сэргээн хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хэн бүхний талархлыг хүлээж байгаа билээ. Гэтэл санаатай, санамсаргүй хоёрын алин болох нь үл мэдэгдэх байдлаар үндэснийхээ соёл, түүхийг хүнийсгэх үзэлд хөтлөгдөн, ахмад үеийнхний чармайж бүтээсэн соёлын ололтыг харь бусдын гавьяа мэтээр ярьж, бичих хандлага цухалзах болсон нь харамсалтай. Энэ үгийг би Монголын анхны сонины үүслийн талаарх зарим ташаа ойлголттой холбогдуулан хэлж байна. 1913 оны 3 дугаар сарын 6-нд Монголын Нийслэл Хүрээнд “Шинэ толь хэмээх бичиг” сонин гарч эхэлснээр үндэсний сэтгүүл зүйн түүх эхэлсэн, уг сониныг соён гэгээрүүлэгч, их эрдэмтэн

Жамсрангийн Цэвээн эрхлэн гаргасан гэдгийг одоогоос гучаад жилийн өмнө Монголын сэтгүүлчдийн байгууллага ээлжит Их хурлынхаа тогтоолоор баталгаажуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд нэг мөр хүлээн зөвшөөрч өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байгаа билээ. Гэтэл зарим залуу судлаач “Шинэ толь хэмээх бичиг” сониныг Оросын дипломатч И.Я.Коростовец удирдаж гаргасан гэсэн дүгнэлт хийсэнтэй санал нийлэх аргагүй байна. Бид энэ асуудалд улс төрийн өргөн хараагаар хандах хэрэгтэйг юуны өмнө хэлье.

И.Я.Коростовец гэдэг хүн монгол сонин гаргахыг санаархаж, уг сониныг эрхлэх хүнийг эрж хайж, энэ асуудлаар эрдэмтэн Ж.Цэвээнтэй арав гаруй удаа уулзан санал солилцож, улмаар Оросын консулын хэвлэх үйлдвэрийг түшиглэн гарч эхэлсэн “Шинэ толь хэмээх бичиг” сониныг өөртөө хамаатуулж, бичиж тэмдэглэсэн зүйл байгааг үгүйсгэх аргагүй. Харин Коростовец ямар зорилгоор монгол сонин гаргахыг чухалчилж байв, тэр нь Ж.Цэвээний эрхлэн гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонины зорилготой адилхан байсан уу? гэдэг асуултад хамгийн эхлээд

хариулах хэрэгтэй болно. Ингэхийн тулд эхлээд И.Я.Коростовец гэж хэн байсныг тодруулах хэрэгтэй болно.

Иван Яковлевич Коростовец бол Оросын эзэнт гүрний хувьд нэрд гарсан дипломатч, харин бусад бага буурай орнуудын хувьд бол их гүрний эзлэн түрэмгийлэх бодлогыг хэрэгжүүлэгч, авьяаслаг ангуучлагч байсан юм. Тэрээр Рио-де Жанейро, Лиссабон, Тяньжин, Бушир, Бээжин, Мароко, Перс зэрэг олон газарт Хаант Оросыг төлөөлж, очсон газар бүхэндээ эзэнт төрийнхөө бодлогыг чадамгай хэрэгжүүлж байв. Тиймээс ч Оросын эзэн хаан түүнд төрийн хамаг дээд одонгоо хүртээж, сайшаан магтаж байсан юм. Коростовец 1912 оны Орос-Монголын гэрээ гэгчийг байгуулах эзэн хааны бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон нь Хятадад ажиллаж байхдаа эхнэр хүүхний асуудалд холбогдож унасан нэр хүндээ сэргээх аятай боломж болсон байдаг. Азид, түүний дотор Монголд Оросын улс төрийн бодлого, ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үйл хэрэгт И.Я.Коростовецийн байгуулсан “гавьяаг” эзэн хаан нь өндрөөр үнэлж, 1913 онд Монголоос буцахын нь өмнөхөн Гэгээн Аннагийн I зэргийн одон хүртээж байсан нь ямартай ч Монголыг мандууллаа гэж олгосон шагнал биш нь тодорхой билээ.

**И**.Я.Коростовец Монголд ямар зорилготой ирсэн, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд юу сэдэж байсныг илтгэх олон баримт байна. Тэрээр 1911 оны намар Оросын Гадаад яамны сайд С.Д.Сазоновт илгээсэн нэг захидалдаа “Хэрэв бид Халхад тэргүүлэх үүрэгтэй байхаасаа татгалзах аваас энэ нь Японд урам өгч, тэд манай байр суурийг эзлэх нь гарцаагүй” (И.Я.Коростовец, 2010) хэмээн бичсэн байдаг. Бас Алс Дор-

нод дахь Оросын нөлөөг өргөжүүлэн тэлэхийн тулд Сибирийн зэрэгцээ төмөр замыг барьж байгуулах” (Russia, Japan and United States in China "Entente Diplomacy and the World") санал дэвшүүлж байв. Тэрээр Гадаад Монголыг “Оросын эдийн засгийн ашиг сонирхлын хүрээ” гэдгийг 1912 онд болсон Орос-Японы хэлэлцээрээр хүлээн зөвшөөрүүлж чадсан нь Монголыг Оросын аж үйлдвэрийн түүхий эдийн бааз болгох зорилгод нь завшаантай хэрэг болсон байна. Ийм санааг бүр XIX зууны сүүл үеэс Оросын худалдаачин Петер Бадмаев хэрэгжүүлэх санаачилга гаргаж эзэн хааны санхүүжилтээр томоохон төсөл хэрэгжүүлж байгаад дампуурсан билээ. Коростовец “Монгол улс өөрөө бие дааж Хятадтай гэрээ байгуулах гэж оролдох нь, түүнчлэн энэ оронтой ойртох гэж оролдох нь Монголын хувьд хөнөөлт үр дагавартай” гэж үздэг байсан нь Монголыг аврах гэсэн санаа биш, Оросын эзэнт гүрний бодлогыг хэрэгжүүлэх зорилготой нь холбоотой байв. Судлаач Ж.Фритерс “Энэ хүн бол Оросын эзэнт улсын хамгийн чадварлаг дипломатуудын нэг бөгөөд Гадаад Монголд Оросын бодлогыг идэвхтэй хэрэгжүүлэх үйл хэргийн судсыг гартаа барьж байсан билээ” гэсэн бол, Японы судлаач Т.Наками “XX зууны эхэн үеийн Монгол дахь Оросын улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд Коростовец, Люба, Шекин, Крупенский зэрэг Оросын авьяаслаг дипломатчдын оруулсан лут их хувь нэмрийг тэмдэглэх хэрэгтэй” (Nakami Tatsuo, 1998) гэсэн байдаг.

Коростовец 1912 оны 8 дугаар сард “Тайван ажиглаж болох ч таатай мөчийг алдаж болохгүй” гэсэн эзэн

хааныхаа сануулгыг хэрэгжүүлж Монголын засгийн газартай хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгчөөр Монгол руу мордсон байна. Ийнхүү томилогдохдоо “Хэрэв халх хүчирхэгжвээс цаашдаа бие даасан төр улсын цөм болж, бусад монгол аймаг угсаатнууд түүнд нэгдэж болзошгүй” гэсэн Гадаад яамны сайд С.Д.Сазоновын анхааруулгатай санал нэгдэж, “Гэрээ хэлэлцээр хоёр талын аль алинд ашигтай байх болно гэдэгт монголчуудыг итгүүлж чадна гэж найдаж байна” хэмээн итгэлтэй хэлж байжээ. Түүний шаргуу тулгалтаар 1912 оны 10 дугаар сарын 21-нд гарын үсэг зурсан Орос-Монголын гэрээ нь мөн чанартаа их гүрний тулгалтаар хүлээлгэсэн дээрмийн гэрээ байсан юм. Уг гэрээнд Монголын талаас оруулахыг хүссэн Монголын нутаг дэвсгэрийн хил хязгаар халдашгүй байх, Орос, Монгол хоёр улс харилцан төлөөний сайд солилцох гэх мэт заалтуудыг хүчээр хасаж, Монгол улс Оросоос өөр улстай зөвшилцөх, гэрээ байгуулах эрхгүй гэсэн заалт оруулсан байдаг. Түүнчлэн Монгол улс Хаант Оросын худалдааны онц эрхийг хангах, Оросын барааг гаалийн татваргүй нэвтрүүлэх, гадаад улстай худалдаа хийхдээ Оростой байгуулсан гэрээний заалтыг зөрчихгүй байх гэх мэт хатуу заалтыг тулган хүлээлгэсэн байдаг.

И.Я.Коростовец Монголтой харилцан ашигтай гэрээ хийсэн биш, харин хар мөртэй луйврын бичигт хүчээр гарын үсэг зуруулсныг эх орноо гэсэн сэтгэлтэй эрдэмтэн судлаачид удаа дараа тэмдэглэсэн байна. Академич С.Чулуун И.Я.Коростовец автономит буюу өөртөө засах эрхийг монголчуудад олгосон дүр үзүүлж эдийн засгийн хамаг эрхийг булаан авах, улс төрийн эрхийг нь хязгаарласан гэрээ

хийх зорилгоор Монголд ирсэн... Монголчуудыг эзлэн захирагч, их гүрний дээрэнгүй нүдээр харж, үл тоогч байсан (itoim.mn, n.d.) гэж сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа дурдсан бол, төрийн шагналт түүхч, доктор Д.Өлзийбаатар Коростовец “Монгол угсаатныг нэгтгэхгүй байх, Оросын ашиг сонирхлын бүс байлгах, эх оронч хөвгүүдийг устгах зорилгоор Монголд хөл тавьжээ” (touristinfocenter.mn, огноо байхгүй) гээд эзлэн түрэмгийлэх бодлогыг нь хүлээн зөвшөөрөхгүй байсан Да лам Цэрэнчимэд болон эх орныхоо тусгаар тогтнолын төлөө эрслэн боссон олон ноёд учир битүүлгээр уван цуван өөд болсны цаана Коростовец байсан гэсэн түүхчдийн дүгнэлттэй санал нийлсэн байдаг. И.Я.Коростовец да лам Цэрэнчимэдийг “Бидний хамгийн гол, хамгийн хэрсүү өрсөлдөгч, хээл хахуульд үл автах, шулуун шударга, хартай хашир хүн” хэмээн тодорхойлж, “Шарын шашны атгаг үзэлд автсан, аливаа шинэ соргог бүхэнд дайсагнан хандагч” (И.Я.Коростовец, 2010) гэх мэтээр үзэн ядаж, Монголын засгийн газрын гишүүдийг “Сайд гэдэг эрхэм нэрийг өөрсдөдөө наачхаад бай-гаа... анхны хүй нэгдлийн үеийн нүүдэлчид” (И.Я.Коростовец, 2010) гэж гутаан доромжилж байсан зэрэг нь эдгээр түүхчдийн таамаглалд итгэх нэг сэжим юм.

**Т**үүх судлаач, зохиолч Б.Номинчимэд “Энэ хүний эх барьсан 1912 оны Орос-Монголын гэрээг дэлхийн 1 дүгээр дайныг хүртэл хийсэн гэрээнүүд дотроос Хаант Оросын хамгийн ашигтай “Колоничлох гэрээ” байсан гэж үздэг юм билээ... Манжийн савраас дөнгөж салаад байсан монголчуудад тэрхүү гэрээгээ хүчээр тулган хүлээлгэжээ”

(Б.Номинчимэд, 2016) гэсэн байхад, сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн “Монголыг колонио болгох гэж тулгаад, түүнд нь саад бологчдыг шууд устгаж байжээ гэж ойлгогдож байгаа юм” (Т.Баасансүрэн, Нэгэн жарны сударласан сургамж, 2022) хэмээн өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн байна. Шуудхан хэлэхэд оросуудын “Тахиа бол шувуу биш, Монгол бол гадаад биш” гэдэг үзлийн үүднээс хандаж байжээ. Гэрээнд Монголын талаас бэлтгэсэн хувилбарыг хумхин базаж, өрөөний булан руу шидэж байсан зэрэг нь доромжлол биш гэж үү. Монголчууд төдийгүй Оросын зарим дэвшилт үзэлт хүмүүс ч Орос-Монголын 1912 оны гэрээг шүүмжилж байв. Тухайлбал тэр үед Чита хотод гарч байсан “Новое время” сонин уг гэрээг “балмад явдал” гэж нэрлэсэн байдаг.

**Х**арин Оросын эрх ашгийг хамгаалах үзэлтэй хэвлэлүүд өөрөөр хандаж байсан юм. И.Я.Коростовецийг нас барсантай холбогдуулж тэдгээр сонинуудын нийтэлсэн мэдээнд “Бээжин, Монгол, Перст Оросын элчингийн албыг хашиж, Оросын ашиг сонирхлыг хэлбэрэлтгүй ур чадвар, хүчин зүтгэлээр төлөөлж байв” (Иллюстрированная Россия, 1933), “1918 онд Антанттай хийсэн Яссагийн хэлэлцээрт Украин улсын элчээр оролцсон Иван Яковлевич Коростовец таалал төгслөө” (Харбинское время, 1933) гэх мэтээр бичиж байлаа.

Улс төрийн иймэрхүү намтартай хүнийг Монголд гавьяат үйлс бүтээсэн, оюун санааны түүчээ болсон тогтмол хэвлэлийг үндэслэсэн хэмээн өргөмжлөх нь шуудхан хэлэхэд эх оронч биш санаа юм. Хаант төрийн үнэнч зүтгэлтэн, бага буурай улс

орнуудыг ангуучлах гарамгай авьяастан И.Я.Коростовецэд Зөвлөлт засаг таалагдаагүй юм. Тэрээр Октябрийн социалист хувьсгал ялсны дараа Хятад, Европ руу цагаачилж яваад 1933 онд Парист нас барсан байдаг.

XX зууны эхний хориод жил бол нэг талаар монголчууд улс үндэснийхээ сэргэн мандлын төлөө тэмцэж эхэлсэн, нөгөө талаар хойт урд хоёр их гүрний түрэмгий бодлогын талбар болж байсан ээдрээ төвөгтэй цаг үе байв. 200 гаруй жил Манжийн эрхшээлд унтаа мэт байсан монголчууд тусгаар тогтнолоо зарлаж, туурга тусгаар улс болсон нь түүхэн гарамгай үйл явдал байсан бөгөөд энэ үйл хэрэгт хүч чадал, оюун ухаанаа зориулахаар Хайсан гүн, Удай ван, баргын Дамдинсүрэн гэх мэт монгол туургатны дэвшилт сэхээтнүүд орж ирсний нэг нь Жамсрангийн Цэвээн байлаа. Тэрээр өндөр боловсролтой эрдэмтэн хүний хувиар Монголын шинэ тулгар төрд тусалж, ард түмнийг соён гэгээрүүлэх ажилд шамдан орсон юм. Энэ үеэс Монголд тогтмол хэвлэл гаргах хоёр сонирхол зэрэгцэн гарч иржээ. Үүний нэг нь Монгол Улсын төрийг засах үйл хэрэгт оюун санааны түүчээ болж, хоцрогдсон буурай ард түмнийг ертөнцийн соёлтой танилцуулж, оюун ухааныг нь нээгдүүлэх зорилготой Ж.Цэвээний сонирхол, нөгөөх нь Монгол Улсыг Оросын колони болгох дээрмийн гэрээгээ сурталчилж, монголчуудын тархийг угаах замаар оросын зүгт татах зорилготой И.Я.Коростовецийн сонирхол байсан юм.

Эхлээд Ж.Цэвээний бодлого, үйл ажиллагааг авч үзье. Түүний бодлого, үйл ажиллагаа тун тодорхой, бас энгийн, ил байв. Тодорхой хэлбэл монголчуудыг гэгээрүүлэх замаар төр

улсынхаа түшиг тулгуур болгохыг зорьж байжээ. Энэ санаагаа хэрэгжүүлэхийн тулд Монгол Ардын Намыг байгуулах анхдугаар Их хурлыг удирдалцаж, үндсэн баримт бичгүүдийг нь зохион батлуулж, Монголд шинэ цагийн иргэний боловсрол, үндэсний хэвлэх үйлдвэр, сэтгүүл зүй, шинжлэх ухааны байгууллагын эх суурийг тавихад тэргүүлэн оролцжээ. Тэрээр монголчуудын үндэсний ухамсрыг сэргээж, шинэ тулгар төр улсынхаа хөгжил дэвшилд хүч, мэдлэгээ зориулах идэвхтэй иргэд болгон төлөвшүүлэхэд тогтмол хэвлэл чухал гэж үзэн Монголын анхны “Шинэ толь хэмээх бичиг” сониныг эрхлэн гаргасан байдаг. Сонин гаргаж, сургуулийн сурах бичиг, бусад ном дэвтэр хэвлэхэд хэвлэх үйлдвэр чухал байсан нь мэдээж. Монгол Улсын Гадаад яам санаачлан бусад яамдын дэмжлэгийг авч Сангийн яамнаас гаргаж өгсөн 1500 цельков (орос цаасан мөнгө)-оор Ж.Цэвээн өөрөө Оросын ШУА-иас хэвлэлийн үсэг, машин тэргүүтнийг авчирч 1912 оны 12 дугаар сарын 30-нд анхны даралт хуудсаа гаргаж “мунхаг харанхуйг эрдмийн зул бадруулж гийгүүлсүгэй” хэмээн Богд хаанд өргөн барьж, мутрын адис хүртэж байсан тухайгаа өөрийн шавь академич Б.Ринченд ярьж байсан нь

бичиг зохиолд үлдсэн хөдөлбөргүй баримт юм. Харин сонин гарахаас өмнө хэвлэх үйлдвэртэй болсон байтал “Шинэ толь хэмээх бичиг”-ийг яагаад Оросын консулын хэвлэх үйлдвэрт гаргав гэдэг нь сонирхол татдаг. Манай судлаачид Ж.Цэвээн сониноо харьцангуй чөлөөтэй гаргахын тулд Оросын консулын нөмөр нөөлөгт тү-

шиглэсэн гэж үзсээр ирсэн боловч уг сониныг Консулын хэвлэх үйлдвэрт хэвлүүлж, өөртөө ашигтайгаар хувиргах гэсэн И.Я.Коростовецийн шахалтанд орсон байж болох нэг сэжүүр байгаа юм. Гадаад яамны хэвлэлийг бодвол Оросын консулын хэвлэл арай дөнгүүр технологитой байсан нь ч бас нөлөөлсөн байж болно.

“Шинэ толь хэмээх бичиг” анхны дугаараасаа эхлээд “Эрхлэгч Цэвээн” гэж цагаан цаасан дээр хараар бичсэн гарын үсэгтэй гарч байсан нь хөдөл-

бөргүй баримт биш үү? Манай зарим судлаач “Монголын үнэн” сонины толгойд Коминтерны Алс Дорнодын хорооны Монгол-Төвдийн хэлтсээс тараана” гэсэн бичгийг үндэслэн Монголын сонин биш, Оросын сонин гээд байдаг атлаа “Шинэ толь хэмээх бичиг” сонины хөлд “Эрхлэгч Цэвээн” гэж байсаар байхад Коростовец гаргасан гээд байгаа нь тун ч ойлгомжгүй байгаа юм.

«

**“Шинэ толь хэмээх бичиг” анхны дугаараасаа эхлээд “Эрхлэгч Цэвээн” гэж цагаан цаасан дээр хараар бичсэн гарын үсэгтэй гарч байсан нь хөдөлбөргүй баримт биш үү? Манай зарим судлаач “Монголын үнэн” сонины толгойд Коминтерны Алс Дорнодын хорооны Монгол-Төвдийн хэлтсээс тараана” гэсэн бичгийг үндэслэн Монголын сонин биш, Оросын сонин гээд байдаг атлаа “Шинэ толь хэмээх бичиг” сонины хөлд “Эрхлэгч Цэвээн” гэж байсаар байхад Коростовец гаргасан гээд байгаа нь тун ч ойлгомжгүй байгаа юм**

»

И.Я.Коростовецийн санаа бодол эрс өөр байсан юм. Тэрээр юуны өмнө гаргахаар зорьсон сониныхоо жолоог өөрийн талын итгэлтэй хүнд атгуулж Хаант Оросын түрэмгий бодлогыг сурталчлах, түүний дотор мөнөөх дээрмийн гэрээгээ зөвтгөх талбар болгохыг зорьж байлаа. Монгол сонин гаргаж, Петербургт сууж байсан Барадиныг эрхлэгчээр нь тавихыг хүсэж захидал бичиж байсан атлаа уг асуудлаар Ж.Цэвээнтэй удаа дараа уулзаж байсан нь “Лам олдохгүй бол буцахдаа залах” гэдэг шиг давхар санаалж байсныг харуулдаг. Сонины нийтлэлийг чөлөөтэй бус байлгаж, Оросын нөлөөг нэвтрүүлж, буриадуудын салан тусгаарлах үзлийг хазаарлан барих тухай ярьж байсан нь үндэс угсаагаа гэдэг Ж.Цэвээнд таалагдаагүй нь мэдээж. И.Я.Коростовец хэвлэх үйлдвэрт зориулж хөрөнгө мөнгө босгох арга сүвэгчлэн Иванов, Малиновский нараас 3500 рубль гаргуулж Консулын мэдэлд шилжүүлсэн (И.Я.Коростовец, 2010) нь зөвхөн сонин гаргахад бус, бүр 1904 онд эх суурь нь тавигдсан Оросын Консулын хэвлэлийг сайжруулах бодлогынх нь үр дүн байсан гэж үзмээр байдаг. И.Я.Коростовец бас “Монгол сонин гаргах хэвлэх үйлдвэрт зориулсан байр монголчууд надад гаргаж өглөө. Өмнө нь хятадууд ашиглаж байсан хоёр давхар модон байшин ажээ...” (И.Я.Коростовец, 2010) гэсэн нь эргэлзээтэй санагдаж байгаа юм. “Шинэ толь хэмээх бичиг” сониныг хаалгах саналыг шашныхан тэргүүлэн Богд хаанд удаа дараа тавьж байсан боловч халдашгүй дархан эрхтэй Оросын консулын байранд байсан учир хэвлэлийг зогсоож чадахгүй байсан тухай Ж.Цэвээн авгай хожим академич Б.Ринченд дурсаж ярьсан

байдаг. Нөгөө талаар сониныг Оросын консулын хүрээнээс гадна, тэр тусмаа И.Я.Коростовецийн олж өгсөн байранд гаргаж байсан тухай Ж.Цэвээн болон бусад эх сурвалжийн мэдээ баримт байхгүй. Бас И.Я.Коростовец Консулын хүрээнээс өөр байр олж сонин гаргахыг зорьж байсан нь үнэн бол мөнөөх 3500 рублийг Консулын мэдэлд шилжүүлэх учиргүй баймаар санагдаж байгаа юм.

**Ж**.Цэвээн, И.Я.Коростовец нарын ажил хэргийн чанартай удаа дараагийн уулзалтын уур амьсгалаас харахад тэд үзэл санаа нэгдэж, бүр тодруулбал Монголд Оросын нөлөөг нэвтрүүлэхийг зорьж байсан И.Я.Коростовецийн сониныг Ж.Цэвээн эрхлэх боломж харагдахгүй байгаа юм. Учир нь тэд уулзах бүрдээ таагүй харилцаж байсан. Коростовец “орос үзэл санаатай монгол сонин” гаргах, Ж.Цэвээн “Монголын тусгаар тогтнолыг хамгаалж, ард түмнийг соён гэгээрүүлэх” гэсэн нь соронзонгийн хоёр туйл шиг эсрэг байр суурь юм.

Эцсийн эцэст сонин гаргах итгэлтэй хүн олдоогүй, өөрийнх нь буцах хугацаа тулчихсан үед Ж.Цэвээний гаргасан монгол сонинд нэрээ хөдөргөж, өөрийнхөө нөлөөнд байсан Консулын хэвлэлд гаргуулахыг ятгажээ гэж үзмээр байдаг.

И.Я.Коростовец “Миний хэвлэн гаргах гэж байгаа сонин “Шинэ толь” нэртэй байх юм. Тус сониныг цэвэр шинжлэх ухаанч шинж чанартай байлгахыг хүссэн Жамцарано энэ нэрийг бодож олжээ” (И.Я.Коростовец, 2010) гэх буюу, “Шинэ толь хэмээх бичиг”-ийн анхны дугаар гарахад “Шинэ толь” сонины маань анхны дугаар өнөөдөр хэвлэгдэв” (И.Я.Коростовец, 2010) гэх мэтээр

өөртөө хамаатуулан бичиж тэмдэглэсэн боловч нийтлэлийг нь удирдан чиглүүлж байсан гэх ямар ч баримтгүйн дээр өөрөө ганц өгүүлэл ч шургуулж амжаагүй байдаг. Түүгээр ч үл барам “Шинэ толь”-ийн анхны дугаарт дэлхий бөөрөнхий гэснийг Гандан хийдийн лам нар дургүйцэж, шашны сургаал номд тэрсэлсэн эрхлэгч Цэвээнийг буруутган, ямар арга хэмжээ авах талаар зөвлөлдөж байгаа тухай хөндлөнгийн хүний байр сууринаас бичсэн нь сонины нийтлэлд хуруу, хошуу дүрж чаддаггүй байсныг нь харуулдаг. Энэ бүхнээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- И.Я.Коростовец монгол сонин гаргаж монголчуудын санаа сэтгэлийг Оросын зүгт эргүүлэх, хүчээр хүлээлгэсэн гэрээгээ сурталчлахыг хүсэж байсан боловч тэр нь бүтэлгүйтэж, аргагүйн эрхэнд Ж.Цэвээний гаргасан сонины нэрийг өөртөө хөдөргөсөн байна.
- Ж.Цэвээний эрхлэн гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонины үйл ажиллагаа, нийтлэлийн бодлогод Коростовец оролцжээ гэх баримт сэлт байхгүй байна.
- И.Я.Коростовец “Шинэ толь хэмээх бичиг” сониныг гаргахад ямар нэг байдлаар оролцжээ гэж үзсэн ч, тэр нь колоничлох бодлогоо хэрэгжүүлж, монголчуудын тархийг угаах төлөвлөгөөнийх нь нэг хэсэг байсан юм.
- Эцэст нь их гүрний колоничлох бодлогыг хэрэгжүүлж, дээрмийн гэрээгээ сурталчлахыг санаархаж байсан хүнийг Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, анхны сонины эх баригч гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

### Эшлэл

1. И.Я.Коростовец. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 19 дэх тал
2. Russia, Japan and United States in China “Entente Diplomacy and the World”. p.19-20.
3. Nakami Tatsuo. I.Y. Korostovets and The Mongol problem of Independence in the early 1910s. –Essays on Mongol studies. UB, 1998, p. 178.
4. (Itoim.mn-Үнэний талд).
5. /[http://www.touristinfocenter.mn/news\\_more.aspx?CateID=0&NewsID=1685/](http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?CateID=0&NewsID=1685/)
6. Коростовец И.Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 361 дэх тал.
7. Коростовец И.Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 92 дахь тал.
8. Номинчимэд Б. 2016. “Монголоо нэхэж буй Монгол” УБ., 90, 92 дахь талууд.
9. Баасансүрэн Т. 2022. Нэгэн жарны сударласан сургамж. УБ., 396 дахь тал.
10. “Иллюстрированная Россия”. Парис., 1933. №3(40)
11. “Харбинское время” сонин. 1933. №48. с.7.
12. Коростовец И. Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 347 дахь тал.
13. Коростовец И. Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 330 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. И.Я.Коростовец. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ.
2. Russia, Japan and United States in China “Entente Diplomacy and the World”.
3. Nakami Tatsuo. I.Y. Korostovets and The Mongol problem of Independence in the early 1910s. –Essays on Mongol studies. UB, 1998,
4. (Itoim.mn-Үнэний талд).
5. Норовсүрэн Л. 2019. “Сэтгүүл зүй” (21 боть зохиол). IV боть. УБ.,
6. Норовсүрэн Л. 2012. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.,

7. /[http://www.touristinfocenter.mn/news\\_more.aspx?CateID=0&NewsID=1685/](http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?CateID=0&NewsID=1685/)
8. Номинчимэд Б. 2016. “Монголоо нэхэж буй Монгол” УБ.
9. Баасансүрэн Т. 2022. Нэгэн жарны сударласан сургамж. УБ.
10. “Иллюстрированная Россия”. Парис., 1933. №3(40)
11. “Харбинское время” сонин. 1933. №48.

### Summary

This article discusses about the people who participated in creating the first Mongolian newspaper. The first newspaper, Shini Toli Khemeeh Bichig, was written by scholar and enlightener J.Tseveen. It is

believed that it was founded by him. There are also researchers who believe that Russian diplomat I.Ya.Korostovets created it. The purpose of this article is to refute that view. J.Tseveen published a newspaper to protect Mongolia's independence and enlighten Mongolians. But I.Ya.Korostovets in 1912, was trying to publish a newspaper to promote the treaty forced upon the Mongols and to implement the imperial Russian occupation policy. This article aims to prove that there is no reason to believe that the first newspaper was created by J. Tseveen.

**Keywords:** culture, treaty, Mongolia, Russia, newspapers, goals, nationalism, interests, public policy, history, printing industry.